

## ЗЭЭЛИЙН ҮЛДЭГДЛЭЭРХ ЖИГНЭСЭН ДУНДАЖ ХҮҮГ ЗАРЛАХ ТАЛААР

Монголбанк тухайн сард олгосон зээлийн жигнэсэн дундаж хүүг төгрөг, валютаар сар бүр тооцон зарладаг. 2015 оны 5-р сараас эхлэн зээлийн үлдэгдлээр тооцсон төгрөг, валютаарх жигнэсэн дундаж хүүг зарладаг боллоо. Уг хүүний цуваа 2014 оны 4 сараас эхэлж байгаа болно.

Зээлийн өрийн үлдэгдлээр жигнэсэн дундаж хүүг цаашид тооцож гаргах нь судалгаа шинжилгээнд ашиглагдах ач холбогдолтой. Мөн банкуудын харилцах, хадгаламжийн хүүтэй харьцуулагдсанаар банкуудын ашигт ажиллагааг илүү оновчтой гаргах давуу талтай юм.

Нийт зээлийн өрийн үлдэгдлээр жигнэж тооцсон хүү 2015 оны 5-р сарын байдлаар төгрөгийнх жилийн 17.6 хувь, валютынх жилийн 12.3 хувь байна. Энэ нь тухайн сард олгосон зээлийн дүнгээр тооцсон хүүтэй харьцуулахад валютынх ижил байгаа бол төгрөгийнх 2.2 нэгж хувиар бага байна.